



НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 12/03

Улаанбаатар хот

«Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай,
сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа,
үйлчилгээ эрхлэх журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “г”, “д” заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.3 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван хоёрдугаар хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь :

1. Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай, сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэх журмыг нэгдүгээр хавсралтаар, төлбөр хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улирлын чанартай, сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа үйлчилгээний зөвшөөрөл олгох цэгүүдийн тоо байршлыг тогтоож, худалдаа үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын дэргэдэх “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн дарга С.Тунгалагт, хяналт тавьж ажиллахыг Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Ж.Ганзориг, дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Н.Сумъяа нарт тус тус даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЭРГҮЙ

Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2019 оны Асарын 29-ны өдрийн
12/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ УЛИРЛЫН ЧАНАРТАЙ СҮҮДРЭВЧТЭЙ БОЛОН ИЛ ЗАДГАЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж, хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг дүүргийн нутаг дэвсгэрт сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөнө

1.3. Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэхдээ аж ахуйн нэгж, байгууллага, иргэд Монгол улсын үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Худалдаа, үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага

2.1. Дүүргийн худалдаа, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлж, дүүргийн Засаг даргын дэргэдэх "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл"-тэй /цаашид "Зөвлөл" гэх/ "Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ" байгуулсан байх

2.2. Улирлын чанартай сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа эрхлэгч нь Зөвлөлөөс тогтоосон байршилд байрлах бөгөөд газар нь зориулалтын дагуу тохижуулсан орчны болон үйлчилгээний эрүүл ахуйн шаардлага хангасан байх;

2.3. Түлш, мод, нүүрс, барилгын материал, элс, хайрга, цемент, шохой, чулууны худалдааг зориулалтаар тохижуулсан цэгт Зөвлөлийн шийдвэрээр эрхлэх;

2.4. Ууц өвчүү, мах чанах үйлчилгээг зориулалтын гал тогоо бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт явуулах;

2.5. Татвар төлөгчөөр бүртгүүлсэн, татвар төлөгч байх

2.6. Худалдагч, тогооч нь эрүүл ахуйн үзлэгт хамрагдсан байх;

2.7. Худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын байгууллагаар шинжлүүлсэн дүгнэлттэй байх;

2.8. Нүүрс, модны ил задгай худалдаа эрхлэгчид нь гарал үүслийн гэрчилгээтэй байх;

Гурав. Худалдаа, үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулах

1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь худалдаа үйлчилгээ эрхлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж, Зөвлөлд хандана. Үүнд:

1.1.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэхийг хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурдах/;

1.1.2. Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар

1.1.3. Мэргэжлийн үнэмлэх

1.1.4. Эрүүл мэндийн шинжилгээний дэвтэр

1.1.5. Хорооны тодорхойлолт

1.1.6. Татварын тодорхойлолт

1.2. Зөвлөл нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногт багтаан үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулах эсэх талаар шийдвэр гаргана.

Дөрөв. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүрэг

4.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь дараах эрхтэй байна.

4.1.1. Холбогдох хууль тогтоомж, журам, стандартын шаардлагыг хангаж, мэдээллийн санд бүртгүүлсэн тохиолдолд худалдаа, үйлчилгээ эрхлэх, холбогдох төрийн үйлчилгээ авах;

4.1.2. Худалдаа, үйлчилгээ эрхлэх, зөвшөөрөл авах, хяналт тавих явцад хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд шаардлага тавих

4.1.3. Энэ журамд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах.

4.2. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй байна.

4.2.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нь ойр орчныхоо 50м талбайд тогтмол цэвэрлэгээ хийж, тохижилтонд онцгой анхаарах ба шаардлага хангасан өнгө үзэмж сайтай гэр сүүдрэвч, фасатка байрлуулах;

4.2.2. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж хогийн сав байрлуулах, эко бие засах газар, муу усны нүхтэй байх бөгөөд орчны болон хөрсний бохирдлыг үүсгэхгүй байх;

4.2.3. Хүнсний болон хоолны чиглэлээр худалдаа, үйлчилгээ эрхлэгчид ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж, Хүнсний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллах;

4.2.4. Баталгаат жин хэмжүүр хэрэглэж, худалдан авагчид савлаж, боодолтой өгөх;

4.2.5. Мэргэжлийн ажилчдаа ур чадварын болон чадамжийн сургалтад тогтмол хамруулж мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг, дэвийг ахиулсан мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй чадавхтай баг бүрдүүлж ажиллах;

4.2.6. Хүнсний зориулалтын цаасан болон даавуун уут, сав баглаа боодлыг худалдаа, үйлчилгээнд нэвтрүүлэх;

Тав. Худалдаа, үйлчилгээг зохицуулах Зөвлөлийн чиг үүрэг

5.1. Засаг даргын дэргэд дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээтэй холбоотой асуудлыг зохицуулж, журмын хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг бүхий орон тооны бус “Худалдаа, үйлчилгээг зохицуулах Зөвлөл” ажиллана.

5.2. Зөвлөлийн дарга нь дүүргийн тухайн асуудал хариуцсан Засаг даргын орлогч, нарийн бичгийн дарга нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт,

нийтийн үйлчилгээний хэлтсийн дарга байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засаг даргын захирамжаар баталгаажуулна.

5.3. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.3.1. Дүүргийн худалдаа, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн санг хөтөлж, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэлжүүлэх;

5.3.2. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагатай "Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ" байгууулах;

5.3.3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, удирдах дээд байгууллагаас гаргасан шийдвэрийг сурталчлах, ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах

5.3.4. Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа үйлчилгээ явуулах байршлыг тогтоох;

5.3.5. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, зөвшөөрөлгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

5.3.6. Түлш, мод, нүүрс, барилгын материал, элс, хайрга, цемент, шохой, чулууны худалдааны төвлөрсөн цэгийг тогтоох, зориулалтын дагуу тохижуулахад хяналт тавих;

5.3.7. Зөвлөлийн Ажлын алба нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтэс байна.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэхэд дараах зүйлсийг хориглоно.

6.1.1. Улирлын чанартай сүүдрэвчтэй болон ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөгдсөн цэгээс бусад байршилд ил задгай хүнсний болон хүнсний бус бараа(сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, самар, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, зайрмаг, квас, ундаа, ус чихэр, зориулалтын төхөөрөмж бүхий түргэн хоолны цэг, хүүхдийн тоглоом гэх мэт), түлээ, нүүрсний худалдаа, ууц, өвчүү, мах чанах, шорлог хийх, загас шарах, хуушуур хайрах зэрэг нийтийн хоолны үйлчилгээ эрхлэх;

6.1.2. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайдил задгай автомашиныг угаах, засварлах шатах, тослох материалын худалдаа, үйлчилгээ эрхлэх;

6.1.3. Гарал үүслийн бичиггүй, мэргэжлийн хяналтын шинжилгээний дүгнэлтгүй, хугацаа дууссан, чанарын баталгаагүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүн худалдах, түүгээр үйлчлэх;

6.1.4. Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан "Насан хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын 3.6 дахь хэсэгт заасан авто зам дээрх худалдаа, үйлчилгээний ажил эрхлэх;

Долоо. Төлбөр хураамж төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах

7.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь худалдаа, үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, тохижилтийн төлбөр хураамжийн орлогыг "Налайх Тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын нэмэлт дансанд төвлөрүүлснээр гэрээ байгуулна.

7.2. Уг хураамжийн орлогыг Төсвийн тухай хуулийн хүрээнд Засаг даргын захирамжаар эрх олгогдсоны дагуу дүүргийн тохижилт, ногоон байгууламж, цэвэрлэгээний ажилд захиран зарцуулагдана.

7.3. Журмын хэрэгжилтийг хангуулан, үйл ажиллагааны тайланг дүүргийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бүтэн жилээр тайлагнана.


Найм. Хяналт тавих

8.1. Худалдаа үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтэс, НМХГ-ын Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс, тухайн хорооны Засаг дарга нар хяналт тавьж ажиллана.

Ес. Хүлээх хариуцлага

9.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2019 оны 04 сарын 19-ны өдрийн
12/103 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ УЛИРЛЫН ЧАНАРТАЙ,
СҮҮДРЭВЧТЭЙ БОЛОН ИЛ ЗАДГАЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Худалдаа, үйлчилгээний төрөл	Хураамжийн хэмжээ /төгрөг/
1.	Сүүдрэвчтэй худалдаа (гэр гуанз -сараар)	80.000
2.	Сүүдрэвчтэй худалдаа (баяр наадмаар гэр гуанз-хоногоор)	20.000
3.	Түлээ, нүүрсний худалдаа эрхлэх (сараар)	40.000
4.	Машинаар түлээ, нүүрс худалдах (сараар)	20.000
5.	Гадны байгууллага, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа сурталчилахад (хоногоор)	20.000
6.	Аялал жуулчлалын (морь, тэмээ, илжиг унуулах, бүргэдтэй зураг авахуулах, бэлэг дурсгалын зүйл) худалдаа, үйлчилгээ (улирлаар)	50.000
7.	Гэр буудал /гэрийн тоогоор, улирлаар /	30.000
8.	Цайны газар /сараар/	80.000
9.	Зайрмаг, ус, ундаа, чихрийн худалдаа (хоногоор)	10.000
10.	Зайрмаг, ус, ундаа, чихрийн худалдаа (сараар)	50.000
11.	Хүүхдийн тоглоом (хоногоор)	10.000
12.	Хүүхдийн тоглоом (сараар)	80.000